



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2023 оны 08 сарын 22 өдөр

Дугаар 402

Улаанбаатар хот

┌ Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай ┐

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Эмгэг судлалын үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 5 нэрийн, нийт 2,823,444.00 (хоёр сая найман зуун хорин гурван мянга дөрвөн зуун дөчин дөрвөн) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Эрүүл мэндийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төгсдэлгэр, Эмгэг судлалын үндэсний төвийн захирал Г.Уянга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132005801  
21-r\_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн  
10 дугаар тогтоолын хавсралт



ЭМГЭГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ  
ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Үндсэн хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Тоо хэмжээ /ширхэг/	Нэгж балансын үнэ /төгрөг/	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл /төгрөг/
	Хөргөгч	2017.08	1	139,844.00	139,844.00
	Кассын машин	2014.07	1	594,000.00	594,000.00
	Хиншүү сорогч	2014.07	4	159,900.00	639,600.00
	РН метр	2018.1	1	220,000.00	220,000.00
	Агааржуулалтын тоног төхөөрөмж	2016.07	1	1,230,000.00	1,230,000.00
	НИЙТ ДҮН		8	2,342,844.00 (хоёр сая гурван зуун дөчин хоёр мянга найман зуун дөчин дөрвөн)	2,823,444.00 (хоёр сая найман зуун хорин гурван мянга дөрвөн зуун дөчин дөрвөн)